

БАТЛАВ.  
ХӨДӨЛМӨР, НИЙГИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

С.ЧИНЗОРИГ

С.ЧИНЗОРИГ

БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

**“ЗАРИМ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ”  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан зарим улс төрийн болон тусгай албан тушаалтнуудын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох шаардлага бий болсон. Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсэгт заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч, зэвсэгт хүчин, хилийн цэрэг ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албан тушаалаас бусад төрийн улс төрийн болон тусгай албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг төрийн албаны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын өргөн мэдүүлснээр цалингийн хэмжээ, сүлжээг төрийн албаны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоохоор заасан байна.

Цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох албан тушаалуудад бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал, үндэсний болон орон нутгийн аудитын газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албан тушаал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, шүүхийн шинжилгээний шинжээч, мэргэжилтэн хамаарч байна.

Эдгээрээс зарим албан тушаалтны цалингийн хэмжээ, сүлжээг Улсын Их Хурал батлахаар салбарын хуульд тусгайлан зохицуулсан байдаг. Тухайлбал, Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Прокурорын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал, Үндэсний болон орон нутгийн аудитын газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалын цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтоосон байна.

Харин дээрх албан тушаалаас бусад буюу Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтний цалингийн хэмжээ, сүлжээг өмнө нь хуульд заасны дагуу тогтоож байгаагүй болно.

**Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Тогтоолын төсөл нь дараахъ заалтыг агуулна:

1.Төрийн албаны тухай хуулийн 11.1.11, 11.2-т заасан улс төрийн албан тушаалыг төрийн албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтай, 13.1.6-д заасан шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч мэргэжилтэнг цагдаагийн байгууллагын офицер ахлагчтай адилтгаж, албан тушаалын сарын үндсэн цалинг тогтоохоор заана.

2.Тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 1995 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлд адилтгах тухай" 63 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай заалтыг тусгана.

3.Тус тогтоолыг Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс эхлэн дагаж мөрдөх тухай тусгана.

**Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар**

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсэгт заасныг үндэслэн доор дурдсан албан тушаалтнуудын цалингийн хэмжээ, сүлжээг тогтооно. Үүнд:

1/Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албан тушаалын сарын цалингийн хэмжээг Улсын Их Хурлын Тамгын газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын цалинтай адилтган тогтоох;

2/Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын албан тушаалын цалингийн хэмжээг сум, дүүргийн Засаг даргын албан тушаалын сарын цалинтай адилтган тогтоох;

3/Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч мэргэжилтэнг цагдаагийн байгууллагын офицер ахлагчийн албан тушаалын цалинтай адилтган тогтоох.

**Дөрөв.Тогтоолын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаарх санал**

Энэхүү тогтоолын төслийг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд тогтоолын төслийг батлахтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 1995 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлд адилтгах тухай" 63 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцно.

--оОо--